

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Од ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/107/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Гантулга Утас: 99372297 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бүрэлтэн гудамж 1,14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 49059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darhanoul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОД СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.БАЯРБИЛЭГ ТАНАА

2024.02.25 № 125

төрийн _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Од сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Од сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Ором нутгийн өмчийн газрын даргын 2025 оны А021 тоот тушаалаар 20,510.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ном, сурах бичгийг бараа материалын дансанд, 2,610.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн залруулан бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 963,973.2 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 17 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4526050078

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Од сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 90 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮНЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	877,745,589.23	606,677,408.15
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	498,559,861.62	29,654,542.94
312	Банкинд байгаа	498,559,861.62	29,654,542.94
3121	Төгрөг	498,559,861.62	29,654,542.94
31211	Төрийн сангийн харилцах	498,559,861.62	29,654,542.94
33	АВЛАГА	-	843,478.24
33	Ажиллагсадтай холбоотой авлага		843,478.24
35	БАРАА МАТЕРИАЛ	379,185,727.61	576,179,386.97
354	Хангамжийн материал	379,185,727.61	576,179,386.97
35470	Бусад хангамжийн материал	379,185,727.61	576,179,386.97
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,358,319,046.78	8,624,470,453.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,358,319,046.78	8,624,470,453.10
392	Биет хөрөнгийн дүн	5,629,671,046.86	6,896,922,453.22
39201	Барилга байгууламж	5,423,402,064.35	6,541,071,387.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,318,642,929.53)	(1,554,174,955.34)
39205	Машин тоног төхөөрөмж	1,270,919,595.80	1,598,035,124.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(449,251,225.47)	(593,339,119.31)
39207	Тавилга, эд хогшил	674,124,354.65	857,424,726.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(156,968,492.42)	(189,889,059.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,962,582.00	17,962,582.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,592,516.44)	(7,185,032.88)
39217	Ном	171,717,613.92	227,016,799.82
393	Биет бус хөрөнгийн дүн	1,728,647,999.92	1,727,547,999.88
39301	Программ хангамж	6,624,300.00	6,624,300.00
39302	Хасагдуулга	(3,324,300.08)	(4,424,300.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,725,348,000.00	1,725,348,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,236,064,636.01	9,231,147,861.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		12,000,478.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,000,478.46
413	Дансны өглөг	-	12,000,478.46
4136	Ажилчдад өгөх		9,543,396.46
41361	Байгууллагад төлөх өглөг		2,457,082.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,327,139,557.83	9,219,147,382.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,327,139,557.83	4,327,139,557.83
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,327,139,557.83	4,327,139,557.83
512	Хуримтлагдсан үр дүн	(100,287,137.11)	882,795,609.67
51210	Өмнөх үеийн үр дүн	(100,287,137.11)	(100,287,137.11)
51220	Тайлант үеийн үр дүн		983,082,746.78
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,009,212,215.29	4,009,212,215.29
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	8,236,064,636.01	9,231,147,861.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	8,385,744,212.00	10,897,039,388.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	840,106,112.00	2,274,282,288.47
120	Нийтлэг татварын бус орлого	840,106,112.00	2,274,282,288.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	162,570,300.00	213,450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,920,300.00	199,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,650,000.00	14,250,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	416,406,438.00	1,745,243,494.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	261,129,374.00	315,588,793.87
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,545,638,100.00	8,622,757,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,356,135,500.00	8,392,999,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,356,135,500.00	8,392,999,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	189,502,600.00	229,757,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	189,502,600.00	229,757,500.00
2	Үйл ажиллагааны зардал	8,501,799,948.86	9,819,724,672.54
21	Урсгал зардал	8,501,799,948.86	9,819,724,672.54
210	Бараа, үйлчилгээний зардал	7,858,874,338.45	8,997,858,521.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	5,783,617,651.00	6,747,590,869.06
210101	Үндсэн цалин	3,762,877,749.00	3,924,730,925.60
210102	Нэмэгдэл цалин	1,688,344,717.00	2,161,893,763.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	205,682,758.00
210104	Урамшуулал	332,395,185.00	455,283,422.46
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	722,968,193.00	829,143,837.07
210201	Тэтгэврийн даатгалын	491,446,150.00	562,347,314.77
210202	тэтгэмжийн даатгалын	58,035,700.00	68,312,100.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	29,017,850.00	33,220,800.54
210204	Ажилгүйдлийн даатгалын	29,017,850.00	33,220,800.00
210205	ЭМ-ийн даатгалын	115,450,643.00	132,042,821.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,192,514.59	192,607,289.37
210301	Гэрэл цахилгааны зардал	36,313,224.50	51,613,050.49
210302	Түлш, халаалтын зардал	84,339,452.60	85,120,614.48
210303	Цэвэр бохир усны зардал	37,539,837.49	55,873,624.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	275,027,183.00	111,526,450.00
210604	Урсгал засварын зардал	275,027,183.00	111,526,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	92,679,656.11	214,241,282.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	4,959,400.00	50,405,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	87,720,256.11	163,836,282.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	826,389,140.75	902,748,794.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	236,854,436.44	286,999,813.37
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	56,750,115.00	44,043,776.06
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	532,784,589.31	571,705,204.98
213	Урсгал шилжүүлэг	642,925,610.41	821,866,150.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	642,615,525.00	818,515,940.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	505,257,525.00	727,820,540.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	137,358,000.00	90,695,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	310,085.41	3,350,210.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	310,085.41	3,350,210.63
3	Үйл ажиллагааны үр дүн	(116,055,736.86)	1,077,314,715.93
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	65,243,847.79	94,231,969.15
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,987,228.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	42,256,619.79	41,457,183.30
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	52,774,785.85
4	Үйл ажиллагааны бус үр дүн	(65,243,847.79)	(94,231,969.15)
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(181,299,584.65)	983,082,746.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,708,208,400.00	8,836,207,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,570,300.00	213,450,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	162,570,300.00	213,450,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	162,570,300.00	213,450,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,920,300.00	199,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,650,000.00	14,250,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,545,638,100.00	8,622,757,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,356,135,500.00	8,392,999,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,356,135,500.00	8,392,999,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	189,502,600.00	229,757,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	189,502,600.00	229,757,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,789,936,520.55	9,171,042,118.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,789,936,520.55	9,171,042,118.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,148,015,410.14	8,349,175,968.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	5,783,617,651.00	6,738,047,472.60
210101	Үндсэн цалин	3,762,877,749.00	3,924,730,925.60
210102	Нэмэгдэл	1,688,344,717.00	2,161,893,763.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	205,682,758.00
210104	Урамшуулал	332,395,185.00	445,740,026.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	722,968,193.00	829,987,315.31
210201	Тэтгэврийн даатгалын	491,446,150.00	562,347,314.77
210202	Тэтгэмжийн даатгалын	58,035,700.00	68,312,100.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	29,017,850.00	33,220,800.54
210204	Ажилгүйдлийн даатгалын	29,017,850.00	33,220,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	115,450,643.00	132,886,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,192,514.59	192,607,289.37
210301	Гэрэл цахилгааны зардал	36,313,224.50	51,613,050.49
210302	Түлш, халаалтын зардал	84,339,452.60	85,120,614.48
210303	Цэвэр бохир усны зардал	37,539,837.49	55,873,624.40
2106	Эд хогшил урсгал засвар	41,629,000.00	43,800,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	629,000.00	-
210604	Урсгал засвар	41,000,000.00	43,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	95,880,656.11	211,883,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,959,400.00	50,405,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	90,921,256.11	161,478,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	345,727,395.44	332,850,690.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	267,635,480.44	291,213,890.77
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	78,091,915.00	41,636,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	641,921,110.41	821,866,150.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	641,611,025.00	818,515,940.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	504,253,025.00	727,820,540.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	137,358,000.00	90,695,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	310,085.41	3,350,210.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	310,085.41	3,350,210.63
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(81,728,120.55)	(334,835,018.68)
22	Хөрөнгийн зардал	254,600,113.00	134,070,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	254,600,113.00	134,070,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	86,487,800.00
223001	Бусад хөрөнгө	-	47,582,500.00

6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(254,600,113.00)	(134,070,300.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(336,328,233.55)	(468,905,318.68)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	162,231,628.07	(498,559,861.62)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(498,559,861.62)	29,654,542.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	81,012,447.54	8,417,364,220.66
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(181,299,584.65)	(181,299,584.65)
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	(100,287,137.11)	8,236,064,636.01
НББ-ийн бодлогын өөрчлөлт			-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			983,082,746.78	983,082,746.78
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	4,327,139,557.83	4,009,212,215.29	882,795,609.67	9,219,147,382.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	8,622,757,100.00	8,619,406,889.37	3,350,210.63	99
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,392,999,600.00	8,392,999,600.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,392,999,600.00	8,392,999,600.00	-	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	229,757,500.00	226,407,289.37	3,350,210.63	98
132001	Орон нутгийн төсвөөс	229,757,500.00	226,407,289.37	3,350,210.63	98
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	712,009,861.62	213,450,000.00	498,559,861.62	29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	199,200,000.00	199,200,000.00	-	100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,250,000.00	14,250,000.00	-	100
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	498,559,861.62	-	498,559,861.62	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,334,766,961.62	8,832,856,889.37	501,910,072.25	94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,382,705,500.00	9,301,762,208.05	80,943,291.95	99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,515,331,500.00	8,483,246,268.05	32,085,231.95	99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,745,442,900.00	6,738,047,472.60	7,395,427.40	99
210101	Үндсэн цалин	4,214,653,900.00	3,924,730,925.60	289,922,974.40	93
210102	Нэмэгдэл	2,153,441,400.00	2,161,893,763.00	(8,452,363.00)	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	205,682,758.00	(205,682,758.00)	-
210104	Урамшуулал	377,347,600.00	445,740,026.00	(68,392,426.00)	118
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	843,180,400.00	829,987,315.31	13,193,084.69	98
210201	Тэтгэврийн даатгал	573,362,700.00	562,347,314.77	11,015,385.23	98
210202	Тэтгэмжийн даатгал	67,454,500.00	68,312,100.00	(857,600.00)	101
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,727,200.00	33,220,800.54	506,399.46	98
210204	Ажилгүйдлийн даатгал	33,727,200.00	33,220,800.00	506,400.00	98
210205	Эрүүл мэндийн даатгал	134,908,800.00	132,886,300.00	2,022,500.00	98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,919,000.00	192,607,289.37	31,311,710.63	86
210301	Гэрэл, цахилгаан	51,520,000.00	51,613,050.49	(93,050.49)	100
210302	Түлш, халаалт	118,186,800.00	85,120,614.48	33,066,185.52	72
210303	Цэвэр, бохир ус	54,212,200.00	55,873,624.40	(1,661,424.40)	103
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,800,000.00	43,800,000.00	-	100
210604	Урсгал засвар	43,800,000.00	43,800,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	201,326,600.00	211,883,200.00	(10,556,600.00)	105
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,405,000.00	50,405,000.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,921,600.00	161,478,200.00	(10,556,600.00)	106
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	457,662,600.00	466,920,990.77	(9,258,390.77)	102
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	415,575,800.00	424,834,190.77	(9,258,390.77)	102
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,086,800.00	42,086,800.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	867,374,000.00	818,515,940.00	48,858,060.00	94
2132	Бусад урсгал шилжүүлэг	867,374,000.00	818,515,940.00	48,858,060.00	94
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	776,678,600.00	727,820,540.00	48,858,060.00	93
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,695,400.00	90,695,400.00	-	100

2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	9,382,705,500.00	9,301,762,208.05	80,943,291.95	99
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	498,559,861.62	(498,559,861.62)	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	29,654,542.94	(29,654,542.94)	-
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	237	208	29	87
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	196	170	26	86
8	Үйлчлэх ажилтан	40	37	3	92

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 8,451.0 мянган төгрөгийн зөрчилд¹ төсвийг хохиролгүй болгох 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 7,851.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Илрүүлэлт: Тус сургуулийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Х.Баярбилэгийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 3-д “Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн захирал Х.Баярбилэг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт “Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.2.2.Илрүүлэлт: Тус сургуулийн нягтлан бодогч, нярав нарт Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 5,707.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

5.3.1 Илрүүлэлт: Тус сургууль нь 2018 оны Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайд, Сангийн сайдын хамтарсан А/024/11 тоот "Орон тооны жишиг норматив батлах тухай" тушаалын хавсралтын Ерөнхий боловсролын сургууль /1-12 дугаар ангитай, 10-12 дугаар ангитай/ нь 1501-ээс их сурагчтай сургууль 3 менежер, нийгмийн ажилтан 2, нягтлан бодогч нярав 2 байна.

Энэ нь Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 тоот "Орон тооны жишиг норматив батлах тухай"-д заасантай нийцэхгүй байгаа тул зөвлөмж хүргүүлээ.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн
Тус сургуулийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Х.Баярбилэгийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-	-
Тус сургуулийн захирал Х.Баярбилэг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144,000.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,144.0	-	-	1	2,144.0	-	-	-	-	-	-	-
Тус сургууль Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, сургуулийн захирлын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Б/113 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан нягтлан бодогч Н.Мөнхцэцэгийг нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлэн 3,118,000.00 төгрөгөөр, Ц.Солонгоог нэг сарын үндсэн цалин 1,484,000.00 төгрөгөөр, нярав М.Гэрэлтуяаг нэг сарын үндсэн цалин 1,105,000.00 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.	1	5,707.0			1	5,707.0	-	-	-	-	-	-	-

Тус сургууль нь 2018 оны Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайд, Сангийн сайдын хамтарсан А/024/11 тоот "Орон тооны жишиг норматив батлах тухай" тушаалын хавсралтын Ерөнхий боловсролын сургууль /1-12 дугаар ангитай, 10-12 дугаар ангитай/ нь 1501-ээс их сурагчтай сургууль 3 менежер, нийгмийн ажилтан 2, нягтлан бодогч нярав 2 байна гэж заасныг зөрчсөн зөрчил илэрлээ.	1	-			-	-	1	-	-	-	-	-
Дүн	4	8,451.0	1	600.0	2	7,851.0	-	-	-	-	-	-